



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/336

Номгон

Нийтийн дасгал хөдөлгөөнийг дэмжих үйл  
ажиллагааг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1, Засгийн газрын 2019 оны 335 дугаар “Биеийн тамир спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” батлах тухай тогтоолын 3.1.7, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2/8 дугаар тогтоолын 2.6.35 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд “Дасгал хөдөлгөөн хийцгээ” идэвхтэй хөдөлгөөнийг 2021 оны 06 дугаар сарын 02-30-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Монгол улсад Ковид-19 цар тахлын улмаас үүсч буй сорилт бэрхшээлийг даван туулахад хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зөв дадал хэвшилд сургах, дасгал хөдөлгөөнөөр дархлааг дэмжих зорилгоор “Дасгал хөдөлгөөн хийцгээ” сарын аянг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Энхбаяр -Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Б.Оюунбаатар -Биеийн тамир, спортын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Д.Энхжаргал-Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Г.Гомбо - Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн

Д.Дэжидмаа -Биеийн тамир спортын газрын нийтийн биеийн тамирын арга зүйч

О.Загдсүрэн -Биеийн тамир спортын газрын заал зохион байгуулагч

М.Энхзаяа -Биеийн тамир, спортын газрын хөнгөн атлетикийн дасгалжуулагч


• 621010855

2.

3.Аймгийн хэмжээнд зохион байгуулагдах “Дасгал хөдөлгөөн хийцгээе” сарын аяны үйл ажиллагаанд зарцуулагдах 2.000.000 /Хоёр сая/ төгрөгийг хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.“Дасгал хөдөлгөөн хийцгээе” сарын аяныг удирдамжийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг 2021 оны 07 дугаар сарын 05-ны дотор Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Б.Батсуурь/-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН